

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ
ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
БҮСИЙН ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ
О.ОТГОНБАЯР ТАНАА

2021.02.05 № 07/527
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаан нь 2020 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар нийт 46 ажил хийсэн бөгөөд ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 24 ажлыг 100 хувь, 19 ажлыг 70 хувь, 3 ажлыг 30 хувь гүйцэтгэсэн гэж үнэлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>596,685,378.00</u>	<u>479,876,425.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	164,201,606.00	4,875,607.00
335	Бусад авлага	164,201,606.00	4,875,607.00
3351	Байгууллагаас авах авлага	164,201,606.00	1,550,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	3,325,607.00
35	БАРАА МАТЕРИАЛ	432,483,772.00	475,000,818.79
351	Түүхий эд материал	376,717,878.75	396,704,878.75
35110	Тусгай зориулалттай материал	376,717,878.75	396,704,878.75
354	Хангамжийн материал	1,633,300.00	24,325,940.04
35410	Бичиг хэргийн материал	1,063,300.00	1,719,420.00
35420	Аж ахуйн материал	570,000.00	5,457,820.00
35440	Түлш, шатах тослох материал	-	200,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	16,948,700.04
35600	Мал амьтад	54,132,593.25	53,970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,598,771,246.16</u>	<u>1,376,190,009.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,598,771,246.16	1,376,190,009.27
392	Биет хөрөнгө	1,597,271,246.16	1,374,090,009.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,400,754,673.00	2,400,754,673.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(985,897,764.07)	(1,117,973,085.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,670,407.00	150,670,407.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(126,940,942.41)	(107,005,511.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	479,482,139.12	473,513,139.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(377,662,819.09)	(436,641,244.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,494,250.60	30,494,250.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,102,031.26)	(20,155,951.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,120,000.00	3,120,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,646,666.73)	(2,686,666.65)
393	Биет бус хөрөнгө	1,500,000.00	2,099,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	2,270,000.00	3,370,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(1,270,000.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,195,456,624.16</u>	<u>1,856,066,435.06</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>165,701,962.18</u>	<u>62,384.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	165,701,962.18	62,384.40
413	Өглөг	165,701,962.18	62,384.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,500,356.18	62,384.40
4136	Бусад өглөг	164,201,606.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	164,201,606.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,029,754,661.98</u>	<u>1,856,004,050.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,029,754,661.98	1,856,004,050.66

512	Хуримтлагдсан үр дүн	2,029,754,661.98	1,856,004,050.66
51210	Өмнөх үеийн үр дүн	2,029,754,661.98	2,032,111,947.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	(176,107,896.88)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,195,456,624.16</u>	<u>1,856,066,435.06</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	407,890,500.00	422,517,324.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,900,000.00	24,044,824.24
120	Нийтлэг татварын бус орлого	6,900,000.00	24,044,824.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,900,000.00	24,044,824.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,900,000.00	24,044,824.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	400,990,500.00	398,472,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	400,990,500.00	398,472,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	400,990,500.00	398,472,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	636,080,033.67	594,444,665.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,080,033.67	594,444,665.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	617,326,889.20	569,357,391.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	236,812,510.00
210101	Үндсэн цалин	-	236,812,510.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	30,657,311.16
210201	Тэтгэврийн даатгал	-	21,074,767.16
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,479,385.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,902,869.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	472,754.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,727,536.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	962,338.00	1,660,496.45
210301	Гэрэл, цахилгаан	962,338.00	1,160,496.45
210304	Түрээс	-	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,716,200.00	32,840,220.54
210401	Бичиг хэрэг	5,256,640.00	2,197,880.00
210402	Тээвэр, шатахуун	16,661,900.00	8,132,593.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,797,660.00	3,102,837.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	17,444,317.24
210408	Бараа материал акталсны зардал	-	1,962,593.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,878,550.00	382,600.00
210604	Урсгал засвар	8,878,550.00	382,600.00
2107	Томилолт, зочны зардал	21,071,050.00	8,869,250.00
210702	Дотоод албан томилолт	21,071,050.00	8,869,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	335,106,880.20	37,664,670.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	333,107,056.20	36,789,670.94
210803	Даатгалын үйлчилгээ	1,418,824.00	

210804	Тээврийн хэрэгслийн татвар	493,000.00	387,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,591,871.00	220,470,332.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	969,651.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	225,591,871.00	219,500,681.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,753,144.47	25,087,274.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,657,658.00	17,234,850.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,896,658.00	14,771,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,761,000.00	2,463,450.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,095,486.47	7,852,424.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,095,486.47	7,852,424.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(228,189,533.67)</u>	<u>(171,927,341.22)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	30,364,904.46	4,180,555.66
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	30,364,904.46	4,180,555.66
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(30,364,904.46)	(4,180,555.66)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(258,554,438.13)</u>	<u>(176,107,896.88)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>565,192,106.00</u>	<u>562,849,275.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,201,606.00	164,201,606.00
120	Нийтлэг татварын бус орлого	164,201,606.00	164,201,606.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,201,606.00	164,201,606.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164,201,606.00	164,201,606.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	400,990,500.00	398,647,669.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	400,990,500.00	398,472,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	400,990,500.00	398,472,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	175,169.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	175,169.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>563,462,106.00</u>	<u>561,749,275.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	563,462,106.00	561,749,275.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,507,355.53	536,662,000.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	962,338.00	1,660,496.45
210301	Гэрэл, цахилгаан	962,338.00	1,160,496.45
210304	Байрны түрээс	-	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,712,060.00	13,812,737.05
210401	Бичиг хэрэг	4,252,500.00	3,260,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,661,900.00	6,949,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,797,660.00	3,102,837.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,448,550.00	596,850.00
210604	Урсгал засвар	9,448,550.00	596,850.00
2107	Томилолт, зочны зардал	21,071,050.00	17,330,750.00
210702	Дотоод албан томилолт	21,071,050.00	17,330,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	328,313,357.53	503,261,167.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	326,313,533.53	502,233,167.36
210803	Даатгалын үйлчилгээ	1,418,824.00	153,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	387,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	493,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,954,750.47	25,087,274.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,657,658.00	17,234,850.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,896,658.00	14,771,400.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,761,000.00	2,463,450.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	169,297,092.47	7,852,424.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	169,297,092.47	7,852,424.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,730,000.00</u>	<u>1,100,000.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,730,000.00	1,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,730,000.00	1,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,730,000.00	1,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,730,000.00	1,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(1,730,000.00)</u>	<u>(1,100,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,288,309,100.20	2,288,309,100.20
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-258,554,438.22	-258,554,438.22
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,029,754,661.98	2,029,754,661.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,357,285.56	2,357,285.56
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,032,111,947.54	2,032,111,947.54
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-176,107,896.88	-176,107,896.88
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,856,004,050.66	1,856,004,050.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	398,472,500.00	390,620,075.86	7,852,424.14	98.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,472,500.00	390,620,075.86	7,852,424.14	98.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,996,000.00	373,385,225.86	4,610,774.14	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,660,500.00	1,660,496.45	3.55	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,160,500.00	1,160,496.45	3.55	100.0
210304	Байрны түрээс	500,000.00	500,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,842,200.00	13,812,737.05	3,029,462.95	82.0
210401	Бичиг хэрэг	3,760,100.00	3,260,100.00	500,000.00	86.7
210402	Тээвэр, шатахуун	7,449,800.00	6,949,800.00	500,000.00	93.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,132,300.00	3,102,837.05	29,462.95	99.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	500,000.00	2,000,000.00	20.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	596,900.00	596,850.00	50.00	99.9
210604	Урсгал засвар	596,900.00	596,850.00	50.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	17,330,800.00	17,330,750.00	50.00	100.0
210702	Дотоод албан томилолт	17,330,800.00	17,330,750.00	50.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	341,565,600.00	339,984,392.36	1,581,207.64	99.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,437,600.00	337,856,392.36	1,581,207.64	99.5
210803	Даатгалын үйлчилгээ	153,000.00	153,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,000.00	387,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,476,500.00	17,234,850.00	3,241,650.00	84.2

2132	Бусад урсгал шилжүүлэг	20,476,500.00	17,234,850.00	3,241,650.00	84.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,181,400.00	14,771,400.00	2,410,000.00	86.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,295,100.00	2,463,450.00	831,650.00	74.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	398,472,500.00	390,620,075.86	7,852,424.14	98.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	398,472,500.00	390,620,075.86	7,852,424.14	98.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	398,472,500.00	390,620,075.86	7,852,424.14	98.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22	22	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	-	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	-	100.0
620004	Гэрээт ажилтан	1	1	-	100.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал О.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын зорилт юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний Аудитын газрын захиалгаар “Төгс нягт гурав аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 сарын 22-ны өдрийн 01/08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь бүс нутагт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлж, малын өвчингүй тайван бүсийг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлж, дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг байгуулан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчинд ээлтэй, экспортын баримжаатай бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;
- Газар тариалангийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх;
- Дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг байгуулан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Байгууллагын удирдлагыг 2020 оны 9-р сард өөрчлөн шинэ удирдлагатай болсон.
- ХХХҮЯ-наас тус байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХХААХҮЯ-ны дотоод аудитын газраас 2020 онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

ХХААХҮЯ-ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн санхүүгийн тайлан дахь орлого үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож нийт зардлын дүн 295,731.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 2,957.3 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 1 хувиар тооцож 5,986.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 339,390.2 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	164,201.6	4,875.6	-159,326.0
Бараа материал	432,483.8	475,000.1	42,516.3
Үндсэн хөрөнгө	1,598,771.2	1,376,190.0	-222,581.2
Нийт хөрөнгө	2,195,456.6	1,856,066.4	339,390.2
Өр төлбөр	165,701.9	62.4	-165,639.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,029,754.7	1,856,004.0	-173,750.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,195,456.6	1,856,066.4	339,390.2

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансдуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 4,875.6 мянган төгрөг болж өмнөх оноос 159,326.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд Сангийн яамнаас авах авлагаар тайлан балансад тусгагдсан 164,201.6 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 2019-2020 онд үүссэн, он удаан жил болсон авлага байхгүй, хувь хүнээс авах авлага 3,325.6 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 1,550.0 мянган төгрөг шатахууны болон бараа материалын авлага байгааг тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 475,000.1 мянган төгрөг болж 42,516.3 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагын шийдвэрээр 24,044.8 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй авсан, 54,861.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 36,390.2 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,376,190.0 мянган төгрөг болж 222,581.2 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл 173,612.2 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр 43,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг өөр байгууллагад шилжүүлсэн, 5,969.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталж данснаас хассан зэргээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө оны эхэнд 2,270.0 мянган төгрөг, оны эцэст 3,370.0 мянган төгрөг болж 1,100.0 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-наас харьяа байгууллагуудын санхүүгийн программыг шинэчилсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 62.4 мянган төгрөг болж 165,639.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд Сангийн яамнаас авах авлагаар, холбогдох газарт өглөгөөр тайлан балансад тусгагдсан шүүхийн шийдвэртэй 164,201.6 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,856,066.4 мянган төгрөг болж 173,750.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 14,626.8 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ХХААХҮЯ-аас үнэ төлбөргүй ирсэн 24,044.8 мянган төгрөгийн бараа материалын орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 41,635.3 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа ажил үйлчилгээний зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал буурсан байна.

Энэ нь 48,969.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр 43,000.0 мянган төгрөгийн үнэтэй тээврийн хэрэгсэл шилжүүлсэн, 5,969.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар руу хаасан 2,357.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь тооллогоор орлогодсон хөрөнгө, татварын өглөг цуцлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 738,900.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 738,900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 340,427.5 мянган төгрөгөөр бууруулж 398,472.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагч төсвийг бодитой төлөвлөөгүй гэж үзэхээр байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхээр 398,472.5 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 398,472.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 390,620.1 мянган төгрөгийг зарцуулж 7,852.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 390,620.1 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь Бараа материал худалдан авах зардлыг 3,029.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,581.2 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 3,241.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 178 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 22 мэдээллийг огт байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,734.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 351,538.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 17,918.3 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн дансанд мэдээлээгүй 329,420.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 4,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тус байгууллагын ажилтнууд 2020 оны 6-8 дугаар саруудад 17,918.3 мянган төгрөгийн малын тэжээл тарьж, өвс хадаж авсан ба санхүүгийн тайланд орлогоор тусгаагүй байсныг бараа материалын дансанд тусгуулж залруулга хийлгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны мэдээллийг дутуу хөтөлсөн 329,420.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 178 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 22 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4,200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар Дорнод аймгийн Халхгол суманд байрлах загварын аж ахуйд газар дээр нь очиж мал амьтан, хөрөнгийн бодитой байгааг үзэх, мөн тэнд тарьж байгаа, туршиж байгаа шилмэл ургацын байдал болон үр дүнтэй танилцах, аудитын горим сорил хэрэгжүүлнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй боловч хуулийн фирмээс зөвлөх үйлчилгээ авч 4,200.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”

1.2 Эрсдэл:

Төсвийг үр ашигтай зарцуулаагүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах:

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/150/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй боловч хуулийн фирмээс зөвлөх үйлчилгээ авч илүү зардал гаргасан.	4,200.0	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг мөрдөж ажиллах;	Захирал	О.Отгонбаяр
2	Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 178 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 22 мэдээллийг огт байршуулаагүй байна.	329,420.0	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.8 дахь заалтуудыг мөрдөж ажиллах;	Захирал	О.Отгонбаяр
ДҮН		333,620.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 104/АД160063

Улаанбаатар хот

САН-2021/150/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын цахим хуудсанд 178 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож, 22 мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "Мэдээллийн үнэ зөв, бодитой иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.8 дах заалтууд, "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал О.Отгонбаяр, нягтлан бодогч М.Энхзаяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ТӨГС НЯГТ ГУРАВ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭРДЭНЭЗУЛ

З.ТУНГАЛАГ

[illegible]